



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 09 өдөр

Дугаар

17/09

Улаанбаатар хот

«Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын эргэлтийн бус хөрөнгийг балансаас
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,201,500.00 (есөн сая хоёр зуун нэг мянга таван зуун) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу тухайн байгууллагын балансад шилжүүлэн данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (С.Уранмандах)-нд зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг (Б.Нэргүй)-т зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалга сугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500000



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

№	Эд хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Компьютер Dell optiplex	Dell optiplex	2019.06.04	ширхэг	3	2,068,000.00	6,204,000.00	6,204,000.00	-	Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газар
2	Принтер /3 үйлдэлт/	Samsung 2070	2019.06.04	ширхэг	4	401,500.00	1,606,000.00	1,606,000.00	-	
3	Принтер	Samsung 3405	2018.12.01	ширхэг	1	192,500.00	192,500.00	101,597.21	90,902.79	
4	Компьютер Asus	Asus	2021.12.15	ширхэг	2	599,500.00	1,199,000.00	632,805.57	566,194.43	
						Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн	9,201,500.00	8,544,402.78	657,097.22	